

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ТӨСВИЙН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

“29.12.Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Засгийн газрын гишүүдэд танилцуулав.


Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтнуудад даалгав:

1.Кибер аюулгүй байдлыг хангахад зориулсан зардлыг төсвийн эдийн засгийн ангилалд тусгах асуудлыг судалж, шийдвэрлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.“Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд;

3.Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт;

4.Мэдээллийн аюулгүй байдлын аудит болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан хугацаанд тогтмол хийлгэж хэвшихийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын удирдлагуудад.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР